



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 766

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалттай холбоотой 85,867.5 (Наян таван сая найман зуун жаран долоон мянга таван зуу) мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Шарын гол сумын ус хангамжийн эх үүсвэрийн гүний худгуудын аюулгүй байдлын талаарх хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулан ажиллах, худгуудад хамгаалалтын хашаа хийлгэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг дараа оны төлөвлөгөөнд тусгах болон орон нутгийн эрх бүхий байгууллагад хүсэлт уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

2.2. Газрын маргаантай, данснаас хасагдсан дулааны станцын хуучин зуухны барилгыг өргөтгөл хийж ашиглах шаардлагатай байгаа тул 2008 онд тус барилгын үндсэн эд, материалыг худалдан авах гэрээ байгуулсан “Дархан Мээж” ХХК-д санал хүргүүлж, эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах.

3. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (П.Баярцэцэг)-т дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2. Батлагдсан хөрөнгө оруулалтад төлөвлөгөөнд багтаан хөрөнгө бэлтгэх, худалдан авалт хийх, өөрчлөлтийг хагас, бүтэн жилээр тодотголд тусгуулах талаар эрх бүхий этгээдэд санал хүргүүлэх, шийдвэрлүүлэх;

123007360

36-r_huraldaan.docx

3.3.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, байгууламжид хамаарах 81,544.0 (Наян нэгэн мянга таван зуун дөчин дөрөв) м2 талбай бүхий газрын маргаантай асуудлыг эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

3.4.Шарын гол сумын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ашиглалтын 9 (есөн) ширхэг худгийн газрыг баталгаажуулах, газар эзэмших эрхийг Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолд заасны дагуу үнэлж санхүүгийн тайланд тусгах;

3.5.Компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, 118,460,621.0 (нэг зуун арван найман сая дөрвөн зуун жаран мянга зургаан зуун хорин нэгэн) төгрөгийн балансын үнэ бүхий, 6кВ-н цахилгаан дамжуулах кабель болон агаарын шугам, тоноглолыг мэргэжлийн байгууллагад шилжүүлэн өгөх, ашиглалт, засвар үйлчилгээг хариуцуулах талаар санал боловсруулан эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

3.6.Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.1.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийнэ” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллах, ашиглалтгүй, маргаантай хөрөнгө, газрын асуудлаар тодорхой ажил зохион байгуулж хэрэгжилтийг Төрийн өмчийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагад тогтоолд заасан хугацаанд ирүүлэх;

3.7.Стандарт хэмжил зүйн газраас олгосон, улсын бүртгэлд бүртгэгдэн Монгол Улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын халуун, хүйтэн усны тоолуур суурилуулах, засварлах 83 дугаартай тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах;

3.8.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
7.66 дугаар тогтоолын хавсралт



“Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн /төгрөгөөр/	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Батлагдсан төлөвлөгөөнөөс зардлыг хэтрүүлсэн.	78,421,450.00	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 76.1.9, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ	Зардал, хөрөнгө оруулалтын ажлыг батлагдсан төлөвлөгөө, эх үүсвэрт багтаан зарцуулах.
2	Үндсэн хөрөнгө зөвшөөрөлгүй худалдан авсан	1,818,545.45		
3	Үндсэн хөрөнгө худалдан авахдаа төсөвт өртгийг хэтрүүлсэн	5,627,500.00		
4	Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга, байгууламжид хамаарах газрыг баталгаажуулж, үнэлж бүртгэлд тусгаагүй.	81544 м2	Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоол	Үнэлж бүртгэлд тусгах арга хэмжээ авах.
5	Газар эзэмших эрх үнэлж данс бүртгэлд тусгаагүй /8 ширхэг/	-		
6	Ашиглалтгүй хөрөнгөд элэгдэл тооцсон	-	ТБОНӨТ хууль, Эрчим хүчний сайдын 2021 оны А/25, А/164 тушаал, татварын тухай хууль	Хууль тогтоомжид заасны дагуу элэгдлийн зардлыг тооцож бүртгэх.
	Нийт дүн:	85,867,495.45 (Наян таван сая найман зуун жаран долоо мянга дөрвөн зуун ерэн таван төгрөг, дөчин таван мөнгө)		